



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№135 /349/

2022.08.02

Тусгай дугаар

БАЙЛДААНЫ ГАВЬЯАНЫ УЛААНЫ ТУГИЙН ОДОНТ, ЖАНЖИН Д.СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 336 ДУГААР АНГИ БАЙГУУЛАГДСАНЫ ТҮҮХТ 90 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ӨРГӨН ДЭВШҮҮЛЬЕ!



МЭНДЧИЛГЭЭ



Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах эрхэм бөгөөд хүндтэй үүргийг биелүүлж, батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан Байлдааны гавьяаны Улааны тугийн одонт, жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн үе үеийн ахмад дайчид, генерал, офицер,

ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчид, ажилтан албан хаагчдаа Хуурай замын цэргийн нийт бүрэлдэхүүний нэрийн өмнөөс болон хувиасаа анги үүсэн байгуулагдсан түүхт 90 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье! Түүхийн хуудас сөхвөл, Бүх цэргийн жанжны 1932 оны 07 дугаар сарын 30-ны тушаалаар "Зургаадугаар морьт дивиз"-ийг байгуулсан нь өнөөгийн Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн үндэс, суурь, дайчин замнал эхэлсэн түүхтэй. Өнгөрсөн зууны туршид тус ангийн удирдлага, нийт бие бүрэлдэхүүн Монгол Улсын төр, засаг, цэргийн дээд командлалаас хүлээлгэсэн үүргийг нэр төртэй биелүүлж, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайны ялалтын тугийг мандуулалцсан гавьяатай бөгөөд энх цагийн бүтээн байгуулалтад, даян дэлхийн энхийг үйлсэд ч манлайлан оролцож ирсэн нь мөрдэс нэгт нөхдийнх нь бахархал юм. "Зүүнбаянгийн дивиз" буюу "Хээрийн академи" нэрээрээ алдаршсан энэхүү анги нь өнгөрсөн 90 жилийн хугацаанд Зэвсэгт хүчний

үе үеийн шилдэг генерал, офицер, ахлагч нарыг эгнээнээсээ төрүүлж, эх оронч үзэл сэтгэлгээтэй мянга мянган хугацаат цэргийн алба хаагчдыг бэлтгэж, монгол цэргийн дайчин түүх, шилдэг уламжлалыг түүчээлэн явааг баярын энэ өдрүүдэд бахархан дурсахдаа таатай байна. Монгол эх орон, төр, ард түмнийхээ өмнө өргөсөн тангаргаа үнэнчээр биелүүлэн, мэргэжил, дадлага, туршлага, ур чадвар, авьяас билгээрээ үлгэрлэн манлайлагч алтан мөрдэст генерал цолтон гэхэд 49 төрсөн нь Зэвсэгт хүчний үе үеийн цэргийн шилдэг дарга нарыг бэлтгэж байсныг илтгэх учиртай. Төр засаг, Зэвсэгт хүчний удирдлагаас өгсөн үүргүүдийг амжилттай гүйцэтгэсний дотор Дорноговь аймгийн Малхын талд "Хэрлэн-73", Дундговь аймгийн Өндөр шилд "Говь-77", Дорноговь аймагт "Найрамдал-79" болон 2008 оноос эхлэлтэй Монгол Улсын Зэвсэгт хүчин, ОХУ-ын Зэвсэгт хүчний хамтарсан "Сэлэнгэ" тактикийн хээрийн сургуулийг 2017 онд өндөр түвшинд зохион байгуулахад тус ангийнхан тэргүүлэх үүрэгтэй оролцсон нь түүхийн хуудаснаа тодоор бичигдэн үлдсэн юм. Хуурай замын цэрэг тодотголтойгоор ангийн түүх, алдар гавьяаг үргэлжлүүлэн

хадгалж, түүхийн хуудсаа амжилт бүтээлээр жилээс жилд улам баяжуулахын зэрэгцээ төр засгийн шийдвэрээр орон нутгийнхаа бүтээн байгуулалтыг нуруун дээрээ үүрч, хүүхэд, залуучуудыг цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлээр төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж яваа Та бүхэндээ талархахын ялдамд мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бүрдүүлж, цэргийн сургалт бэлтгэл нь шинжлэх ухаан, технологи, инновацад суурилж, бэлэн байдлаа бэхжүүлэх дараагийн шинэ зууны хөгжил дэвшилд Та бүхнийг онцгой амжилт үзүүлнэ гэдэгт итгэл төгс байна. Эх орондоо үнэнчдийн тангараг өргөн, энх цагийн соргог манаанд 90 жил бат найдвартай зогсож, "Зүүнбаянгийн дивиз"-ийн түүхийн хуудсыг амжилт бүтээлээрээ дархалсан үе үеийн эрхэм алба хаагчдаа баярын мэнд дахин дэвшүүлж, цэргийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл хэрэгтээ ямагт манлайлагч байхыг хүсэн ерөөе!

Монгол цэргийн яруу алдар үеийн үед мандан бадрах болтугай!

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ БРИГАДЫН ГЕНЕРАЛ Ч.ЦОГТЖАРГАЛ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 336 ДУГААР АНГИЙН ТҮҮХТ 90 ЖИЛИЙН ОЙ ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР БОЛЖ БАЙНА

Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн түүхт 90 жилийн ой эл өдрүүдэд тохиож байгаа бөгөөд ойд зориулсан цэргийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээ өнөөдөр ангийн жагсаалын талбайд боллоо. Энэхүү ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд Дорноговь аймгийн Засаг даргын орлогч Г.Март, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, ЗХЖШ-ын АУГ-ын дарга бригадын генерал С.Дашзэвэг, Зэвсэгт хүчний ХЗЦК-ын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа Д.Өлзийбаяр, "Зүүнбаян холбоо"-ны тэргүүн бэлтгэл хошууч

генерал С.Баасанхүү, 6 дугаар мотобуудлагын дивизийн анхны захирагч чөлөөнд байгаа хошууч генерал Т.Баатар, мөн дивизийн захирагч чөлөөнд байгаа хошууч генерал Ч.Цэрэндагва, 6 дугаар мотобуудлагын дивизийн захирагчийн орлогч, "Зүүнбаян холбоо"-г үүсгэн байгуулагч чөлөөнд байгаа хурандаа Д.Пүрэвсүрэн, БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагуудаас уригдан ирсэн зочид төлөөлөгчид, дивиз, нэгтгэл, хорооноос төрөн гарсан Монгол төрийн генералууд, үе үеийн ангийн захирагч нар, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, ангийн бие бүрэлдэхүүн оролцлоо.



АМЬДРАЛЫН МИНЬ 10 ЖИЛ АВШИГ ШИНГЭСЭН ЭНЭ САЙХАН АНГИТАЙ ХОЛБООТОЙ



Бэлтгэл хурандаа Б.Цагаан:



-Тэртээх 1986 онд тухайн үеийн ЗХУ-ын Ленинград хотын Артиллерийн академийг төгсөж ирээд ахмад цолтойгоор Ардын Армийн 207 дугаар ангийн захирагчаар томилогдож байлаа. Эл ангидаа 1989 оныг хүртэл ажиллаад 1990-1993 онд Ардын Армийн 136 дугаар ангийн захирагч, 1993-1996 онд Ардын Армийн 133 дугаар анги буюу Артиллерийн тусгай хорооны захирагчаар тус тус томилогдон ажилласан юм. Өөрөөр хэлбэл, миний ажил, амьдралын 10 жил Зүүнбаян хэмээх энэ сайхан авшиг шингэсэн нутагтай салшгүй холбоотой. Тэр үед Мотобуудлагын дивиз ид өргөтгөн зохион байгуулагдаж, ёстой л өрнүүн их ажил буцаж байлаа шүү дээ. Нийт 6 хороо, 10 тусгай батальонтой байсан гээд л бод доо, хэр өргөн бүрэлдэхүүнтэй байсан нь эндээс тод харагдана. Байлдагчаас

эхлээд хэн хүнийг л цэргийн эрдэмд жинхэнэ утгаар нь сурган боловсруулдаг байлаа. Тиймдээ ч "Хээрийн академи" хэмээх нэрээр ард олондоо алдаршсан юм шүү дээ. Тухайн үед дивизийн захирагчаар Г.Дамдинсүрэн генерал ажиллаж байлаа. Ер нь "Их говийн гарнизон"-оос олон сайхан генерал цолтон төрөн гарсан бөгөөд миний хувьд тэдний цөөнгүйтэй нь хамтран ажиллаж, тэднээс асар олон зүйлд суралцсандаа сэтгэл өөг байдаг юм. Ингээд Артиллерийн тусгай хороо буюу 133 дугаар ангийн минь үндэс суурь, үргэлжлэл болсон Зэвсэгт хүчний 336 дугаар ангиар овоглогдсон үе үеийн ахмад буурлууд, өдгөө эл ангийг түүчээлэн авч яваа удирдлага, нийт бие бүрэлдэхүүнд анги үүсэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж, ажлын их амжилт, амьдралын гэгээн бүхнийг хүсэн ерөөе. Та бүхэн сайхан баярлаарай.



ХЭДЭН НАСААР ЗАЛУУЖСАН МЭТ Л САНАГДАНА

Бэлтгэл ахмад Д.Нацагхүү:

-Би 1966 онд Барилгын техник мэргэжлийн сургуулийг ерөгч мэргэжлээр төгссөн хүн. Сургууль төгсөөд Увс аймгийн Барилга контор, хотын Барилга трестэд ерөгч-арматурчин, барилгын мастер, барилгын даамал зэрэг ажлуудыг хийж байгаад 1978 онд Зүүнбаяндахь Барилгын цэргийн 023 дугаар ангид томилогдсон юм. Тэгээд 1994 оныг хүртэл эл ангид барилгын даамал, барилгын инженер, хөдөлмөрийн аюулгүй байдлын байцаагч инженер, диспетчер инженер зэрэг албан тушаалуудад шат дараалан ажиллаад гавьяаныхаа амралтад гарсан даа. Ажиллах хугацаандаа уурын зуух, клуб, 24 танхим бүхий хичээлийн байр гээд чамгүй бүтээн байгуулалтыг гардан гүйцэтгэсэн. Тухайн үед хамт олныхоо хүчээр цогцлоож байсан барилга, байгууламжуудаа өнөөдөр эргээд харах үнэхээр сайхан юм аа, ажлын амт мэдрэгдэх шиг л болж байна. Ер нь өнөөдөр миний сэтгэл маш өндөр байна. Яагаад гэвэл Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн маань түүхт 90 жилийн ойн баярын арга хэмжээ ёслол төгөлдөр их сайхан болж байна. Энэ ангитай ажил, амьдралынхаа түүх дурсамжийг холбосон ахмад буурлууд олноор хүрэлцэн иржээ. Тухайн үед хамтран ажиллаж, мөр зэрэгцэн зүтгэж байсан хүмүүстэйгээ уулзалдаж, дурсамж дурдатгалаа хуваалцах шиг сайхан зүйл хаана байх



билээ. Түүнчлэн олон жил өмсөөгүй дүрэмт хувцсаараа өнөөдөр гоёлоо. Яагаад ч юм бэ нэлээд хэдэн насаар залуужсан мэт тийм сайхан мэдрэмж төрж байна. Ингээд ангийн 90, "Зүүнбаян холбоо"

ТББ-ын 20 жилийн түүхийг хамтдаа бүтээсэн үе, үеийн ахмад буурлууд, бидний хойч үе болсон залуус дүү нартаа ойн баярын мэнд дэвшүүлж аз жаргал, амьдралын сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ОЛОН САЙХАН ДУРСАМЖ ТОЛГОЙД БУУЖ, СЭТГЭЛ СЭРГЭЖ БАЙНА

Бэлтгэл хошууч Ч.Сүрэнжав:

-Би УБДС-ийг 1969 онд төгссөн, монгол хэлний багш мэргэжилтэй хүн. Тэгээд 1973 онд цэргийн албанд татагдаж одоогийн Зэвсэгт хүчний 032 дугаар ангид хоёр жил алба хаагаад 1975 онд офицерын эгнээнд шилжин Зүүнбаянд томилогдон ирж байлаа. Тодруулбал, тэр үеийн 2 дугаар мотобуудлагын бригадын 139 дүгээр ангид батарейны улс төрийн орлогчоор ирсэн юм. Ард олондоо "Их говийн гарнизон", армийнхандаа "Хээрийн академи" нэрээрээ алдаршсан, өрнүүн их ажил буцалсан тийм л сайхан талбарт хөл тавьж байсан минь саяхан мэт санагдаж байна. Хугацаат цэргийн албанаас офицерын эгнээнд дөнгөж элссэн надад сурч мэдэх зүйл ч их байсан, тэр үеийн мундаг чадварлаг дарга нараасаа их ч зүйлд суралцаж боловсорсон доо. Миний хувьд Зүүнбаяндаа 1975-1989 оныг хүртэл тасралтгүй 14 ажиллаж амьдарсан хүн. Түүхт 6 дугаар морьт дивизийн улбаа, залгамж халаа болсон эл ангийнхаа 90 жилийн ойн баярт оролцож байгаадаа туйлын баяртай байна. Ангийн хашаагаар орж ирүүт л олон сайхан дурсамж толгойд бууж,



сэтгэл сэргэж байна. Бидний залгамж халаа, хойч үе болсон залуус маань золбоо хиймөртой, зовхи нь өөдөө байгааг харах, ангиа маш сайхан өнгөтэй, өөдтэй авч явааг нь үзэхэд сэтгэл үнэхээр хангалуун байна. Ингээд

төрөлхонгийнхаа үе үеийн удирдлага, хамт олон, мөр зэрэгцэн алба хааж байсан хэн бүхэнд анги үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Сүлд дуу

ИХ ГОВИЙН ГАРНИЗОН

Ая АЖ, МУУГЗ П.Хаянхярваа

Үг МУГЖ Г.Жанчив

Тэнгэрийн хаяатай айлсан буусан
Таван эрдэнийн дуртмал өлгий
Тэмээний хэвтэр шиг дулахан
Тэнгэрхэн говьдоо хайрын заяатай
Энх төрийн сүлдээ тэргүүндээ дээдлээд
Эх орны манаанд жагсаж явна
Илчит нараа алган дээрээ өргөөд
Их говийн гарнизонд дуулж явна
Хангай бүсгүйн захидлыг авчирсан
Холын гийчнээ хоймортоо уриад
Хамгийнхаа дээдээр хүндлэн зочилсон
Халамжит хүмүүсийн сайхан нутгаа
Энх төрийн сүлдээ тэргүүндээ дээдлээд
Эх орны манаанд жагсаж явна
Илчит нараа алган дээрээ өргөөд
Их говийн гарнизонд дуулж явна
Хармагийн төгөл шиг элснээс амьтай
Халшираа нь үгүй зоригт хүмүүстэйгээ
Ардын цэргийн алдар баяраараа
Алтанхан говьдоо дуулал нэгтэй
Энх төрийн сүлдээ тэргүүндээ дээдлээд
Эх орны манаанд жагсаж явна
Илчит нараа алган дээрээ өргөөд
Их говийн гарнизонд дуулж явна

ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОО



Тус ангийн офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсэн цаг мөчөөс хувь нэмрээ оруулан хүлээсэн үүргээ биелүүлж ирсэн. Тодруулбал, 2004 онд "Иракийн эрх чөлөө" ажиллагаанд оролцох Монгол Улсын цэргийн багийн II ээлжид ахмад Ц.Буянтогтох, ахлагч Б.Батхүрэл нар анхны энхийг сахиулагчдын шанг тавьж байсан бол 2006 онд баруун Африк тивийн Сьерра-Леон улсад явагдсан "UNMIL" энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын цэргийн багийн II ээлжид ахлах дэслэгч О.Ганбаяр, ахлагч Б.Батхүрэл, дэд ахлагч С.Гантулга, У.Сансарсайхан, Ц.Энхболд нар НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд оролцсон анхны цэнхэр дуулгатнууд болсон юм.

Тус ангийн энхийг сахиулагч дайчдаас Монгол Улсын Зэвсэгт хүчний 2007 оны "Шилдэг энхийг сахиулагч" тодорч байсан нь манай ангийн бие бүрэлдэхүүний сургалт дадлага, туршлага, үр чадвар өндөр байдгийг илтгэнэ. Ангийн бүрэлдэхүүнээс НҮБ-ын мандаттай энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд хамгийн олон удаа үүрэг гүйцэтгэсэн Мотобуудлагын батальоны ахлагч, сургагч ахлагч Н.Ганзориг 5 удаа үүрэг гүйцэтгэсэн шилдэг энхийг сахиулагч юм. Өнөөдрийн байдлаар БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын цэргийн багийн 11 дүгээр ээлжид 2 офицер, 7 ахлагч анги, байгууллагын удирдлага, хамт олны хүлээлгэсэн итгэл найдварыг даан үүрэгээ амжилттай гүйцэтгэж байна.

МОНГОЛ УЛСЫН ХАМГИЙН ТОМ ЗАДГАЙ УСАН БАССЕЙН

Анх энэхүү бассейныг 1952-1967 онд Зүүнбаянд ажиллаж байсан нефтийн үйлдвэрийн ажилтнууд барьжээ. Урт нь 50, өргөн нь 25, гүн нь 4 метр хэмжээтэй. Хүүхдийн зориулалттай хэсэг нь 0.50-1.5 метр, дотор нь зааны барималтай бол томчуудын хэсэгт дээрээс үсрэх тавцантай, тохилог сайхан бүтээн байгуулалт бий. Бассейныг тойруулан мод суулгаж, зүлгэжүүлсэн бөгөөд эргэн тойрон сандалтай. Энэхүү бассейн Зүүнбаян цэргийн хүрээний офицер, ахлагч, ажилтан албан хаагчид

төдийгүй Зүүнбаянчуудыг сэрүүцүүлэхээс гадна бассейны урд хэсэг дэх бүжгийн талбайд зуны дэлгэр цагт орой бүр бүжиг явагддаг байв. Монголд усанд сэлэлтийн улсын аварга шалгаруулах анхны тэмцээн 1967 онд Зүүнбаян дахь энэхүү бассейнд болж, эмэгтэйчүүдээс Н.Алтантуяа, эрэгтэйчүүдээс н.Андрей нар улсын аваргаар шалгарч, эхний гурван байрыг Зүүнбаяны залуучууд эзэлж, алт, мөнгө, хүрэл медаль хүртэж байсан нь түүх болон тэмдэглэгддэг.

